

**МОНГОЛ НУУЦ ТОВЧООНЫ 234-Р ЗҮЙЛИЙН
НЭГ ХЭЛЛЭГИЙН ТУХАЙ¹**

Jens Christian Thomas
/Лейпциг/

2007 онд Д.Отгонтуяа Монгол Судлал-д² МНТ-ны 234-р зүйлийн нэгэн хэллэгийн тухай бичиж санаагаа илэрхийлснээс үүдэн би энэ өгүүлэлийнхээ санааг авсан учраас талархлаа илэрхийлье. Д.Отгонтуяагийн өгүүлэлд олон орчуулгыг дурдсан тул би дахин тоочилгүй Гениш (Haenisch)³ болон Таубегийн (Taube) герман орчуулгад ч үгчилсэн маягаар орчуулсан байдгийг нэмж хэлье.⁴

МНТ-ны энэ хэллэгийг хэрхэн ойлгох тал дээр орчуулагчдын ихэнх нь шууд үгчилсээр ирсэн бол Д.Отгонтуяа шилжсэн утгыг олоход анхаарч, шилжсэн утгаар орчуулахаас аргагүй гэж үзсэн нь зүйтэй юм.

Тийнхүү шилжсэн утгыг авч хэлэлцвэл ухаж ойлгох, илэрхийлэх хоёр боломж бий. Үүнд,

1. Зөвхөн хэллэгээс илэрч буй шилжсэн утга.

2. Хэллэгийг үгчлэн авахын хамтаар хам сэдвээс илэрч буй шилжсэн утга.

Д.Отгонтуяа эхний боломжийг дагасан бол миний хувьд хоёр дахь боломжийг

¹ Өгүүлэлийн тухай зөвлөлгөө өгч засаж тусалсан Доктор Э.Мөнх-Учрал ба Доктор Б.Даваасүрэнд би чин сэтгэлийн талархалаа илэрхийлье.

² Д.Отгонтуяа: “Монгол Нууц Товчоон”-ы нэгэн хэлцийн орчуулгын тухайд. Монгол Судлал XXVII (285), 2007. 171-176 т.

³ “[...] dort von dem Abfallgemüse essen und ein Mistfeuer brennen lassen”; орч.: “тэнд хаягдсан ногооноос идэж өтөг бууцийн гал түлж” (Haenisch 1948, 111 т).

⁴ Отгонтуяагийн иш татсан орчуулгууд хэвлэлүүд:

- “Ш.Гаадамба: Монголын Нууц Товчоон, УБ, 1990
- Кү.Дорба: Монголын Нууц Товчоон. Шинжааны Ардын хэвлэлийн хороо, 1987
- Монголын Нууц Товчоон. Ихмянгадай Иринчиний сэргээлт, Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо. Хөх хот, 1987
- Ч.Р.Намжиловой: Сокровенное сказание монголов. Элиста, 1990
- Д.Пүрэвдорж: Монголын Нууц Товчооны шинэ орчуулга тайлбар. УБ, 2006
- Д.Цэрэнсодном: Монголын Нууц Товчооны орчуулга тайлбар. Үндэстний хэвлэлийн хороо, 1993
- Ш.Чоймаа: Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал 1. УБ, 2006
- Элдэндэй Ардажав: Монголын Нууц Товчоон - Сийрүүлэл тайлбар. Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн хэвлэлийн хороо. Хөх хот, 1996
- F. W. Cleaves: The Secret History of the Mongols Harvard University Press 1982
- N. Dorjgotov, Z. Erendo: The Secret History of the Mongols, Brill: London, 2004
- Paul Kahn: The Secret History of the Mongols, North Point Press 1984
- Urgunge Onon: The Secret History of the Mongols, London 2001”

дагаж үндэслэн тайлбарлая.

Дээр дурдсан хэллэгийг иш татвал:

qoq idejü

*qoma'ul tülejü yabutuqai*⁵

Хог идэж

Хомоол түлж явтугай

А) Хэллэгийн хам сэдэв ба шийдэх асуудал

Хэллэгийг анх уншихад хялбар, утга тодорхой мэт харагдах боловч хам сэдвийн хүрээнд уялдуулан үзвэл утга зохицохгүй байгаа нь тодорхой билээ.

МНТ-ны §225-§234 хүртэл Чингис Хаан хэшигтэнд холбогдох (*хэвтуул, хэшиг, хорчин гурав* гэсэн үг) зарим шийдвэр гаргадаг. Энэ дунд хэшигийн тоо хамгийн их байсан боловч (8 түмэн хишигтнээс 2 түм нь л хэвтүүл (§226)) хэвтүүлийг хамаардаг тушаал хамгийн чанга хатуу бөгөөд Чингис Хаан зөвхөн хэвтүүлээ магтан дуулсан (§230) зэргээс үзэхэд хэвтүүл хамгийн чухал гэдэг нь илэрхий болж байна.

Жишээлбэл, шөнийн хамгааллаар хан халдлагад өртөх аюултай асан учраас хэвтүүл үнэнч, баталгаатай, итгэж болохуйц байхаас аргагүй билээ (§227-д жагсааж дурьдсан шийтгэл үзнэ үү). Хэвтүүл орд өргөөний ойрхон эргэн тойрон сууж үүд хамгаалах,⁶ шөнө болоод орд өргөөнд ойртож гэтэж явах хэнийг ч барих, орохыг завдсан хүний толгой авах гэх мэт тушаалтай байсан.⁷ Мөн хэн ч шууд орох, хэвтүүлийн тухай асууж авах, хэвтүүлээс дээд суурь дээр сууж болохгүй бөгөөд эсрэг үйлдвэл баригдана (§229-ын эцэст). Бусад албаас гадна хэвтүүл бээр ордны зарц, тэмээчид, үхэрчдийг хамааран захирч өргөөний тэргийг⁸ засаж туг хамгаалж хааны идээ ундааг “даргалж” (хаан хордуулагдахгүйг хянан харгалзах гэсэн үг) өргөөнд хэн орох гарахыг ажиглан шалгаж үүдний дэргэд сууж хаантай хамт ан авлах зэрэг үүрэг эрхтэй байсан (§232). Түүгээр барахгүй бас өдөр нь хэвтүүл хааныг хоцроон үлдээн байлдаанд явахыг хориглосон ба хааны алтан амь сахина⁹ гээд ойрхон байх тушаалтай байсан (§233) бөгөөд заргад оролцож морь арчлах үүрэг оногдуулсан билээ (§234).

§230-д Чингис хаан удаан хугацаагаар алба залгуулсан хэвтүүлээ магтахдаа гэрээ ээрэн, эргэн тойрон хэвтэж тайвнаар унтуулж эсэргүү байдал, аюулаас дандаа итгэлтэй хамгаалсаар ирсэн хэмээнэ. Хэвтүүлийг тодотгосон үгс нь *өлзийт, чинг сэтгэлтэй, итгэлтэй, уриарах* (уриалаг)¹⁰ байх бөгөөд үнэхээр хааныг амар амгалан байлгаж хаан ширээнд суулгасан (§230), өөрийн *nendü'üt qutuq* (сахиус мэт) хэмээжээ (§231).

⁵ МНТ-ны бүх иш татсан газруудыг *Ligeti*-ээс авсан (Ligeti 1971, 203 т).

⁶ § 229: *bidan-tur söni kebt'e'ül qonan atuqai; kebt'e'ül söni ordo horčin gebtejü e'üten daruju* (Ligeti 1971, 197 т).

⁷ § 229: *naran šinggeksen-ü qoyina ordo-yin qoyina'un urida'un ketügeljen yabuqu gü'in-i bariju; kebt'e'ül söni oroqun haran-i ekit anu dalbaru müriis anu ba'utala čabčiju* (ibid.).

⁸ Эх сурвалжид *ordo-yin ger tergen-i* бичсэн байна (Ligeti 1971, 201 т).

⁹ § 233: *ta kebt'e'ül lü minu altan amin sakimui* (Ligeti 1971, 202 т).

¹⁰ Уламжлалсан *uriyarqun* гэсэн үг *uriya* (урия) гэдэг үгээс *r*-дагавараар үүссэн *uriyar-* гэдэг үйл үгийн олон тоотой *-qu/kü* дагавараар бүтээсэн үүсмэл үйлт нэр юм. Чоймаа үүнийг уриархан гэж уншаад уриалаг гэж тайлбарласан (Чоймаа 2011, 193-т).

Товчхон хэлбэл хэвтүүл нь хааны алтан амийг сахиж, биеийг нь хамгаалах чухал үүрэгтэй, хааны найдаж итгэсэн хүмүүс байсан бол бүх хэшигтэн найдвартай оролдлогтой хүмүүс байх ёстой бөгөөд хэшигтний захирагч ер бусын чадвартай, чадалтай хүн байлтай.

Бүх хэшигтэн тургууд¹¹ (харуул анги)-ын захирагч бол Дөдэй чэрби байжээ. Мөн Дөдэй чэрби зарим талаар дээр дурьдсан хэвтүүлийг захирах үүрэгтэй хийгээд асарч байгаа ордны зарц, адуучин, хоньчин, тэмээчин, үхэрчнийг захирахдаа орд өргөөг эргэж тойрон, орд даран хамгаалах ёстой байснаас үзвэл бас хэвтүүлийг ч захирч байсан ажээ.¹² Гар бичмэлд “захирах” хэмээхийн оронд *uqaǰu* < *uqa-* гэсэн ба *mede-* гэсэн үгийн хэрэглээнээс үзвэл бас “захирах, удирдах” гэсэн утгатай байсан нь тодорхой байдаг.¹³

“Орд даран” (*ordo darun*) гэдгийн утгыг нягталбал, хятад орчуулгаар “дандаа” гэсэн байдаг нь үнэхээр оносон уу гэдэг асуудал гарч ирнэ. Хятад орчуулгын дагуу “*байнга, дандаа*” гэсэн утга илтгэх *darui* хэмээх үгтэй холбоотой байх бололтой.¹⁴ Энэ хоёр үгийн үндэс нь *daru-* гэдэг үйл үг бөгөөд нэг талаар *-n* гэсэн үйл үгээс үг бүтээх дагавраар үүссэн нөхцөл үг (*converbum adverbiale*) нөгөө талаар *-i* гэсэн үйл үгээс үг бүтээх дагавараар бүтсэн үг байна (ж. МНТ-ны §56, *boli* < *bol-*).

Үүнээс үзвэл МНТ-ны §229 *e'üten daruǰu bayiǰsat kekte'ül* гэсэн хэлцтэй (үүд хамгаалж байсан хэвтүүл гэсэн үг) харьцуулбал, §234-ийн *ordo darun* гэсэн хэлц бас орд өргөөг хамгаалах гэсэн утгатай болохоор үгчлэх боломжтой юм.¹⁵

Энэ чухал үүрэгтэй, дээд алба хааж байгаа “Дөдэй чэрби даран аж ордын хойноос хог идэж, хомоол түлж явтугай хэмээн (Чингис Хаан) зарлиг болов”. (§234)

Дээр дурьдсан хам сэдвээс үзвэл Дөдэй чэрбид хандаж хэлсэн үгсийг доромжилсон шууд утгаар бус шилжсэн утгаар ойлгох нь зүй.

Б) Орчуулга. Тайлбар.

Эрдэмтэдийн хийсэн орчуулгад, ялангуяа хятад хадмал орчуулгыг дагаж *goγ* гэсэн үгийг “*өвсний үлдэгдэл*” гэж үндэслэн орчуулж ирсэн. Onon, de Rachewiltz, Чоймаа нарын орчуулгадаа хийсэн тайлбар сонирхолтой юм.

1. Onon:¹⁶

*“grazing his herds on pastures
already grazed by the herds of others,
and burning cakes of dried horse-dung”*¹⁷ гэж орчуулаад:

¹¹ Чоймаа турхагууд гэж галигласан (Чоймаа 2011, 196 т). Дунд үеийн монгол хэлэнд гийгүүлэгчийн дэргэд бүх төвөнхийн авиа дуугүй байдаг.

¹² § 227: *niken kešik kešikten-i medeǰü kešikten-i ǰasaǰu orotuqai* (Ligeti 1971, 195 т).

§ 234: *ordo-yin ger-ün kö'üd-i* (Ligeti 1971, 203 т).

§ 234: *bürin kešikten turqa'ud-i ordo horč'in ordo-yin ger-ün kö'üd-i adu'učin qonič'in temēc'in hükeč'in-i ordo darun Dödei-č'erbi uqaǰu atuqai* (Ligeti 1971, 203 т).

¹³ Ж.: МНТ-нд -р зүйлд: *qamtuq Mongqol-i Qabul-qahan meden aba* (Ligeti 1971, 33 т) гэх мэт олон жишээ.

¹⁴ Haenisch 1939, 33 т.

¹⁵ Vide Cleaves-ыг зааж буй de Rachewiltz (2004, 841 т).

¹⁶ Paul Kahn-ын орчуулга адилхан (ibid. 147 т).

¹⁷ Орч.: “*бусад хүмүүсээр мал бүр идэшилүүлсэн бэлчээрт малаа идэшилж хатсан хомоол түлж*”.

“I.e., Dodai-cherbi will be so busy that he will have no time to look after himself properly. *Qoq*, translated here as ‘left-over scraps’, can also mean ‘bad quality grass’, ‘chaff’, ‘refuse’; as a fuel, dried horse dung was considered inferior to dried cow dung. Dodai-cherbi’s appointment was, nonetheless, an honour”¹⁸ хэмээн тайлбарлажээ.

2. De Rachewiltz бээр *qoq* (*qoγ*) гэсэн үгийн жинхэнэ утга нь “‘sweepings, scraps, remnants of food, garbage’, which we find in the living languages and dialects as well as in the literary language”¹⁹ гэж нотолж уйгур хэлнээс авсан үг мөн гэжээ. De Rachewiltz энэ хэллэгийн тайлбарт Onon-ын тайлбарыг ишилсэн аж. Onon, de Rachewiltz хоёр Дөдэй-чэрбийн ажил үүрэг их байснаас үнэхээр хог мэт хоол идэхээс аргагүй байсан гээд түүнчлэн энэ хэллэгийн хоёр дахь мөрд байгаа хомоол гэсэн үгийг *аргал* хэмээх үгийн оронд зөвхөн толгой холбох зорилгоор хэрэглэсэн гэж үзжээ.²⁰

Түүний орчуулга нь:

“Eating scraps of leftovers,

Burning dried dung”²¹ гэж шууд үгчлэн орчуулсан байна.

3. Ш.Чоймаа²² бээр энэ хэсгийг “*хог итэж, хомоол түлж явтугай – Их нүүдлийн ард хаягдаж гээгдсэнийг бүрэн хамаарч яв гэсэн үг болой. «Итэж» - этэж, цугдуулж бөөгнүүлэх; эртний түрэг хэлэнд «итэ-» хэмээх нь мөн адил утгатай буй*” гэж тэмдэглэжээ.²³

4. Д.Отгонтуяа *qoγ* гэдэг үгийн язгуурыг Сэцэнцогтын язгуурын толь бичгээс²⁴ иш таган “*qoγ* гэдэг үгийг *qay* үүсмэл гэж үзсэн байх”²⁵ бөгөөд энэ “*qay*” гэсэн язгуур “алтайн язгуурын бараг бүх хэлэнд ижилхэн байдаг гэж болно”. Тиймээс бас “*хатах*” гэсэн үг энэ язгуураас үүссэн бөгөөд “Чингэхлээр *qoq idejü* гэсэн хэллэг бол “аливаа юмнаас үлдэж хатаж хоцорсон юмыг идэх” гэсэн шиг анхдагч утга байна” гэсэн дүгнэлт хийжээ.²⁶ Түүнчлэн, “[...] орд гэрийн хамаг баг идээнд дарагдах хүн нь Додай чэрби болж таарлаа. Эндээс *qoq idejü* гэсэн хэллэгийн анхдагч шууд утга нь “үлдсэн хатсан юм идэж” гэсэн утга боловч шилжсэн утга нь орд өргөөний аж ахуй хамаг л ажлыг хариуцаж гэсэн утга мөн” бөгөөд орчин цагийн “баг идээнд баригдах” гэсэн хэллэгтэй харьцуулахуйц байна гэжээ.²⁷

Энэ хэллэгийн хоёрдугаар хэсэг нь “сүүл барьж явах, ард явах, сүүлдэж явах, даруухан явах гэсэн шилжсэн утга болно” хэмээн тайлбарлаад “хомоол хамах”

¹⁸ Орч.: “Додай-чэрби их ажиллаж огт завгүй байсан учраас биеэ асрах боломжгүй байна.” Үлдсэн нови” гэж орчуулсан *Qoq* гэдэг үг бас “муу чанартай өвс, хэрчсэн сүрэл, хаягдал” гэсэн утгатай болж байна. Түлш болгон хэрэглэхэд аргалаас хомоол муу гэж үзэж ирсэн. Тийм боловч Додай-чэрбийн тушаал нь хүндлэлтэй байсан“. (Onon 2001, 220 т).

¹⁹ Орч.: “тоос шороо болсон хог нови, хоолны үлдэгдэл, хаягдал” гэдэг нь өнөөгийн хэл аялгуунуудад ч бичгийн хэлэнд ч байсаар байна” (de Rachewiltz 2004, 841 т).

²⁰ “The word for ‘dried dung’ (used for fuel) is hier *qota’ul*, which alliterates with *qoq* (de Rachewiltz 2004, 841 т).

²¹ Орч.: “үлдсэн нови идэж, хомоол түлж” (de Rachewiltz 2004, 162 т).

²² Dorjgotov/Erendo-гийн орчуулга адилхан буй (180 т).

²³ Ш.Чоймаа 2011, 196 т.

²⁴ Sečenčoytu: Mongyol-un üges-ün ijaγur-un toli. Öbör mongyol-un arad-un keblel-ün qoriy-a. 1988.

²⁵ Д.Отгонтуяа 2007, 174 т.

²⁶ Д.Отгонтуяа 2007, 175 т.

²⁷ Д.Отгонтуяа 2007, 175 т.

гэсэн хэллэгтэй харьцуулж болох бөгөөд “үхрийн аргал мэтийн том товир түлшийг биш, адууны хомоол мэт хөнгөн авсаар түли түлэх гэсэн”-тэй утга нь холбоотой аж” гэжээ.²⁸

Д.Отгонтуяагийн англиар

“*He will be responsible for campsite's work*

And follow the move modestly and quietly”.²⁹ гэж орчуулав.

Га) Дэвшүүлэх санал.

Өмнө өгүүлсэн санаа, орчуулгыг нэгтгэн өөрийн саналаа хэлэхээс өмнө хэрэглэх онолын тухай нэг үг хэлье.

Гаа) Үгийн гарлыг тэмдэглэхийн тухай.

Аливаа үгийн гарал үүслийг тогтооход энэтхэг-европ хэлний харьцуулсан түүхэн хэл шинжлэл (Indogermanische Sprachwissenschaft, Indo-European Linguistics)-ийн зарим тохирох арга зарчмуудыг хэрэглэх нь чухал юм.

Габ) утга зүй.

Зарим үг хэлбэрийн хувьд тохирдогдоос нэг гаралтай мэт харагдах боловч утга зүйн талаасаа сэргээсэн язгуур үндэстэйгээ тохирч байх ёстой. Учир нь ижил дуудлагатай язгуур үгс энэтхэг-европ өвөг хэлэнд бас олон байсан. Жишээлбэл, эртний герман хэлний *bero* < **bher-ō(n)* “баавгай” болон *beran* < **bher-an* “авчиргах” гэсэн үгийн язгуурын аль аль нь **bher-* боловч үгийн сангийн хувьд нэг нь нэр үгийн язгуур, нөгөө нь үйл үгийн язгуур. Хэрэв **bher-ō(n)* гэсэн үгийн **bher-*г үйл үгийн язгуур гэж үзвэл *-*ō(n)* гэсэн дагавар залгаж **bher-ō(n)* буюу “онцгой авчирагч” гэсэн утгатай үг үүснэ. Гэвч *bher-ō(n)* гэдэг үг бол герман хэлний “хүрэн, бор” гэсэн утгатай *braun* < **bhr-uH-n* хэмээх үгтэй нэг гаралтай болох ба “бор зүсмийн (амьтан)” буюу *баавгайн* нэр болно. Тийм учраас *хог, хогшил* гэсэн хоёр үг хоорондоо огт холбогдолгүй.³⁰

Ер нь аливаа үгийн гарлыг ярихдаа өөр хэлнээс орсон эсвэл тухайн хэлний уугуул үг үү, анхдагч утга нь шилжсэн үү, үгүй юү гэх мэт асуудлыг шийдвэл зохилтой.

Гаг) Үг зүй.

Ямар нэг язгуур үндсийн араас залгасан дагаврыг жишээлбэл, монгол хэлнийх үү, түрэг хэлнийх үү, хэл зүйн үүрэг, утгын хувьд ямар үүрэгтэй вэ гэдгийг тодорхойлон тэмдэглэх ёстой. Эсвээс “*мөхсөн*” (тухайн хэлэнд хэзээ ч бүтээлч бус, өөр хэлнээс авсан үг байж болно) нэг дагавар байлаа гэж бодоход улмаар язгуурын үндсэн утгыг тогтоох боломжгүй юм. Бас нэр үгийн язгуурыг үйл үгийн язгуураас салгах хэрэгтэй.

Гад) Авианы хууль.

Эртний язгуурыг сэргээх юм уу олон хэлний үгийг харьцуулахдаа нэгэнт тодорхой болсон авианы хуул(иуд)ийг баримтлахгүйгээр сэргээх, харьцуулах нь субъектив үр дүнтэй. Тэр мэт авианы хуульд дүрэмд үл харшлах байдлын зарчмыг XIX зуунд германы младограмматистууд (Junggrammatiker) боловсруулжээ.

²⁸ Ibid.

²⁹ Орч.: “орд (үгч. *оршиж суух газар*)-ын ажлын хариуцлагатай байж нүүдлийг даруухан, чимээгүйгээр дагаж явтугай” (Отгонтуяа 2007, 175 т).

³⁰ Д.Отгонтуяа тэднийг холбогдолтой гэж үзсэн (2007, 174-5 т).

Нэгэнтээ тогтсон авиан зүйн хуультай зөрж байвал дүрэмд харшид тохирсон авиан зүйн хууль байх ёстой. Жишээлбэл, V зууны хуучин зүүн герман (Ostgermanisch, Eastern Germanic) готи/готонес (Goten, Goths) нэртэй хүмүүсийн хэлэнд бүх богино *e (/ɛ/) эгшгээс i (/i/, <i>) эгшиг үүссэн. Гэхдээ уг авиан зүйн хуулинд харшилдаг тохиолдол нь <r, h, hv> (≈ /r, ɣ, ɣβ/) гийгүүлэгчийн өмнө *e (<ai>, /ɛ/) эгшиг хадгалагдаж үлдсэн эсвэл i эгшиг болсон, хожим i эгшиг дахиад e болсон гэж үзвэл энэ тохиолдолд тохирох бас нэг авиан зүйн хууль байна.

Утга зүй, үг зүй, авианы хууль гурвыг түүхэн-харьцуулсан хэл шинжлэлд салгалгүй хэрэглэх ёстой. Жишээлбэл, энэтхэг-европ латин, грек хоёр хэлний “*бурхан*” гэсэн утгатай, нэг гаралтай мэт харагдаж буй *deus*, *θεός* (theós) гэдэг хоёр үг хэлбэрээрээ их адилхан боловч хоорондоо огт холбоогүйг дээр дурьдсан гурван зарчмыг үндэслэн баталж болно.

Эцэст нь үг зүйн бүтцийн хувьд аливаа “*үгийн нас*” нь эх сурвалж бичигт тэмдэглэгдсэн насаас чухал. Учир нь ямар нэгэн эртний дагавар хэрэглэгдэхээ байсан тохиолдолд орчин цагийн хэлэнд уг дагавараар шинэ үг бүтээж болохгүй юм.

Гб) Зохиогчийн дэвшүүлж буй санаа.

Onon, de Rachewiltz хоёрын тайлбар үндэслэлд итгэхэд бэрх. Өмнө өгүүлсэнчлэн чухал ажил алба хааж байсан Дөдэй-чэрби мэт хүн үнэндээ зарцаас муу хоол идэж байсан гэж үү?! Түүнээс гадна “*grazing his herds on pastures already grazed by the herds of others*” гэвэл Дөдэй-чэрби ордны адуу мал бусад хүмүүсийн нэгэнтээ идээшилсэн бэлчээрт буух нь юу бол.

Профессор Ш.Чоймаа эхний мөрийг их сонирхолтой тайлбарласан боловч зарим нэгэн асуудал басхүү хариултгүй хэвээр байна. Тэрээр *ide-* гэсэн үгийг *ite-* гэж үзсэн. Гэвч эртний (XIII зууны өмнөх) түрэг хэлэнд *ite-* гэсэн үйл үг тааралддаггүй³¹ бөгөөд *idi-* гэж “хураах” (“собирать”)³² гэсэн утгатай үйл үгийг *evdi-* гэсэн үгийн оронд буруу уншиж галигласан байна.³³ Тийм учраас “этэх” гэж “хураах” гэсэн утгатай монгол үйл үг нь дээр дурьдсан түрэг үгтэй холбогдолгүй бөгөөд монгол хэлэнд *ete-/ide-*³⁴ гэсэн сэлгэлт байхгүй байна.³⁵

Бас түрэг хэлний зөвхөн үеийн эцэст орсон *-t* гийгүүлэгч монгол хэлэнд *-d* гийгүүлэгчээр сэлгэдэг бол бусад тохиолдолд түрэг хэлний *-t-* нь монгол хэлний *-t-* гийгүүлэгчтэй дүйцнэ.³⁶

Түрэг хэл монгол хэл хоёрын хооронд эхний авианы *e/i* гэсэн эгшгийн сэлгэлт нь зөвхөн түрэг хэлний *idi*, монгол *эзэн* гэсэн үгст байгаа гэвэл авианы хуулийн эсрэг, ганцхан тохиолдол учраас үгийн гарлын шинжилгээнд холбоогүй биз ээ.³⁷

Д.Отгунтуяа нь *qoγ* гэсэн үгийн гарлын тухай бичихдээ Сэцэнцогтын үгийн

³¹ Надеяев нар 1969, Clauson 1972 үзнэ үү.

³² Надеяев нар 1969, 203 т.

³³ Clauson (1972, 42 т) үүнийг илэрхийлж үзүүлсэн.

³⁴ Түрэг хэлэнд зөвхөн *et-* гэж “*совершать*” юм уу “*неть*” гэсэн утгатай үг байгаа байна (Надеяев нар 1969, 186 т).

³⁵ Нэг ганцхан *t > d* гэсэн дүрэмд харш нь “*В слове qadūni ‘его жестокость’ (= письм. qatayū inu) наблюдается *t > d. Пример этот является единственным*” (Поппе 1938, 51 т).

³⁶ Poppe 1960, 49-51 т.

³⁷ Clauson 1972, 41 т.

гарлын талаарыг үндэс болгосон байна. Гэвч Сэцэнцогтын номд өгсөн мэдээлэл алдаатай байна. Жишээлбэл: *qoγ- *qay- *ay- гэсэн үеэр эхэлж буй янз бүрийн үгсийг шилэлгүй нэг нэгтэйгээ холбуулж ямар нэгэн авианы хууль, сэлгэлтийн нөхцөл өгөлгүй, тухайн үгийн түүхийн судлал, дагаврын үүргийн судлал хийлгүй дансалсан байна.³⁸ Тийм учраас “*хамар*” гэсэн үг “*хог*” гэсэн үгтэй холбоотой эсэхийг тодорхойлоогүй тул “*хог*” гэвэл хатах явцад хамаагүй гэдгийг хэлэхээс аргагүй болов уу.

Д.Отгонтуяагийн “*хогоол идэж*” гэсэн хэсгийн тухай хэлсэнчлэн “*хогоол хамар*” гэсэн орчин цагийн хэллэгтэй үнэхээр харьцуулж болох бол “*And follow the move modestly and quietly*” гэж орчуулах нь нийцэхгүй, зөвхөн “*хойноос/хамгийн сүүлд дагаж явтугай*” гэж орчуулах ёстой байна биз.³⁹

Гба) “*хог*” гэсэн үг

Орчин цагийн өмнөх хэлний толь бичгүүдэд *хог* гэсэн үг нь⁴⁰ “*junk, trash, remainder*”,⁴¹ “*Satz, Rest*”,⁴² “*kehricht, überbleibsel, krume*”,⁴³ “*dust particles; sweepings, dirt; garbage*”,⁴⁴ “*ныль, крохи, сорь, остатки, навозь*”,⁴⁵ гэх мэт утгатай болоод орчин цагийн монгол хэлээр “*хаягдал, үлдэгдэл*”,⁴⁶ “*нови, хаягдал, үлдэгдэл [...] хэмхдэг, үйрдэс [...] талхны хог; чихрийн хог*”,⁴⁷ “*Abfall [...] Krümel*”,⁴⁸ “*трусха, мусор, сор*”⁴⁹ гэсэн утга илтгэнэ.

Түүнээс үүссэн “*хоγ|хр мörγ хоγ|дз idnē das pferd frist die überbleibsel des heus*”,⁵⁰ “*qoyliqi* пастись на травы, ходить на подножном”,⁵¹ “**хоглох** доедать, собирать остатки кормов”,⁵² “*хоглох* малын хээр бэлчээрлэн идээшлэх” гэхэд “*хогдох* хог нунтаг болох”,⁵³ “*хоглох* Малд бог өвс, бордооны зүйлийг бага сага идүүлэх” гэхэд “*хогдох* элдэв хаягдлын нунтаграх: талх үйрч хогдох”⁵⁴ гэх мэт үгсээс үзвэл *хог* гэсэн үгийн үндсэн утга нь гол төлөв өвстэй холбогдолгүй байж бага сага байдал, үлдэгдсэн чанар ач холбогдолтой байсан нь илэрхий болох тул “*хэмхлэсэн өвс*”⁵⁵ гэх хятад орчуулгад зөвхөн *хэмхэлсэн* гэсэн үг нь угийн утгыг тэмдэглэхэд *өвс* гэсэн үг нь тайлбар л байна.

³⁸ Д.Отгонтуяа 2007, 174-5 т.

³⁹ Түүнээс гадна “[...] орд гэрийн хамаг **баг** идээнд **дарагдах** хүн нь Додай чэрби болж таарлаа” гэвэл “баг идээнд баригдах” гэсэн хэллэгтэй үнэхээр адилхан байна уу (Отгонтуяа 2007, 175 т)? Сүүлч нь “нүгэл хилэнц их хийх” гэж утгатай биш үү (Сүлд-Эрдэнэ нар 2013, 74 т).

⁴⁰ *Хог* гэсэн үг Мукаддимат ал-Адаб-д байхгүй байна (Поппе 1938).

⁴¹ “*qoγ ügei undefiled, completely*” (Krueger 1978, 282 т).

⁴² Орч.: “шаар, үлдэгдэл” (Zwick 1853, 192 т).

⁴³ Орч.: “новш, үлдэгдэл, үртэс (хөрс)” (Ramstedt 1935, 181 т).

⁴⁴ Орч.: “*тоосны жижиг хэсгүүд, шавар, нови, тоос гэх мэтээс бүрдсэн хог нови*” (Lessing нар 1960, 951 т).

⁴⁵ Kowalewski 1844-49, 958 т.

⁴⁶ Чоймаа нар 2011, 798 т.

⁴⁷ Я.Цэвэл 1966, 681 т.

⁴⁸ Орч.: “*хаягдал [...] үйрдэс*” (Vietze 2005, 346 т).

⁴⁹ Муниева 1977, 591 т.

⁵⁰ Орч.: “*морь нь өвсний үлдэгдэл идэж байна*” (Ramstedt 1935, 181 т).

⁵¹ Голстунский 1894, 146 т.

⁵² Муниева 1977, 591 т.

⁵³ Я.Цэвэл 1966, 682 т.

⁵⁴ Дамбажав 2010, 637 т.

⁵⁵ Rachewiltz 2004, 841 т.

“Хог” гэсэн үгийн гарлыг мөшгөө. Түрэг хэлнүүдэд XIII зуунаас өмнө баримталсан *qoγ* гэсэн үгийн утга “*сор, соринка (в пище или глазу)*”,⁵⁶ үндсэн утга нь “*dust*”⁵⁷ гэж байсан бөгөөд өөр үгтэй холбоотой, үйл үгээс үүссэн нэр байлтай. Тийм үйл үг гэвэл⁵⁸ *qop* “*весь*” < **qo-p* “*суусан, үндэслэсэн*” → болсон, бүрэн”, *god-* “*класть*”,⁵⁹ “*to put down, abandon, give up*”,⁶⁰ *qou-* “*класть*”,⁶¹ “*to settle down*”⁶² (< **qoñ-*) гэсэн үгийг дурдаж болох хийгээд утгаас үзвэл энэ үйл үгсийн язгуур (**qo-*) “*аажуу уужуу унаж суух, зөөлөн тавиад хэвтэх*” гэсэн утга байсан бөгөөд “үйл үгийн үр дүнг”⁶³ тэмдэглэх -*γ* гэсэн дагаврын үүргээр⁶⁴ “*аажуу уужуу унасан юм*” → “*моос*” гэсэн утга болон хөгжсөн бололтой. Тэгвэл, монгол хэлний “хог” гэсэн үг түрэг хэлнүүдийн нэгээс орсон байж магадгүй.

Үүгээр “*новиш, моос*” гэх мэт утгыг тайлбарлаж болох авч утга зүйг амархан бүрэн тайлбарлахгүй тул бас монгол хэлэнд холбоотой язгуур олдох эсэхийг үзье.

**qo-* гэсэн эхлэлтэй олон язгуур байгаа боловч утга зүйн үүднээс зөвхөн дараах үгсийг анхаарах боломжтой байна. Үүнд: *qoγusun*, *qobur*, *qoru-*, *qorçai-*, *qotui-*, *qongqur*, *qoki*, *qomsa*, *qoçur-*.

Гбβ) “*qoγusun*” гэсэн үг

Энэ үгийн бүтцийг **qo-γu-sun* гэж задалж болох бөгөөд -*sUn* гэсэн дагавар нь үйл үгэнд залгасан дагавар буюу “*to form nouns designating the result of action*”⁶⁵ гэсэн утгатай эсвэл нэр үгэнд залгасан дагавар буюу “*to form nouns of which the meaning is usually the same as that of the primary word*”⁶⁶ гэсэн утгатай юм.

Энэ -*sUn* гэсэн дагаварын өмнөх *qoγu-* гэсэн үндсийн талаар би нэг өгүүлэлдээ *γu-* гэсэн дагавар нь үйлээс үйл үг юм уу нэр үг үүсгэх боломжтой, үйлийн үр дүнг илэрхийлэх үүрэгтэй гэж магадалсан.⁶⁷ Түүнчлэн **qoγu-* гэдэг үгийг “*юмгүй (байгаа) байх*” гэж тодорхойлоод **qo-* гэсэн язгуур нь “*юмгүй болох*” гэж тэмдэглэх нь дүгнэлт гарч байна.

Гбγ) “*Qobur*” гэсэн үг

Qoγusun гэсэн үгийн тухай дээр хэлсний дагуу -*bur* гэсэн дагавар нь үйл үгээс үүсмэл нэр үгсийг бүтээх ёстой. Үүний дагуу -*bur* гэсэн дагавараар бүтээсэн үгсийн жишээг үзвэл нэр, үйлийн аль алинаас үг бүтээж байна. Жишээлбэл:

- нэр үгээс үүссэн: *ulabur*, *çagabur*, *talabur* зэрэг.
- үйл үгээс үүссэн: *quriyabur* (< *quriya-*), *singgebür* (< *singge-*), *kögebür* (<

⁵⁶ Надеяев нар 1969, 452 т.

⁵⁷ Clauson 1972, 609 т.

⁵⁸ Эдгээр үгсийг Clauson нэг гаралтай гэж үзсэн (Clauson 1972, 578 т).

⁵⁹ Надеяев нар 1969, 451 т.

⁶⁰ Clauson 1972, 595 т.

⁶¹ Надеяев нар 1969, 453 т.

⁶² Clauson 1972, 632 т.

⁶³ Gabain 1950, 70 т. Илүү нарийхан Erdal (1991, 222-223 т) тайлбарсан.

⁶⁴ “*Resultat des Verbuns, das passiv ist; aktives Substantiv und anderes*”; орч.: “үйл үгийн идэвхгүй утгатай болох үр дүн; идэвхтэй нэр үг гэх мэт” (von Gabain 1950, 70 т).

⁶⁵ Орч.: “үйл үгийн үр дүнг тэмдэглэх нэр үгсийг бүтээх” (Poppe 1954, 44 т).

⁶⁶ Poppe 1954, 49 т.

⁶⁷ Thomas 2011. 319-20 т.

köge-), *yobur* (*yo-dai*, *yo-du-yur*, *yo-ju-yur* харьцуулна уу) зэрэг.

Этгээрийн дунд *хураавар*, *шингэвэр* тодорхой байж *-bur* гэсэн дагавар үйлийн үр дүнгийн утгатай юмыг тэмдэглэж байна. Чингэхлээр *хөөвөр* гэсэн үг хөөх (хавагнах)-ийн үр дүнгийн утгатай юм болох ислийн хийгээр газар хөөнгөрч томорсон намаг⁶⁸ юм уу хөвсгөр, шигүү бус сэвсгэр юм⁶⁹ гэсэн утгатай билээ. Тэгэхэд *говор* (“навчгүй мод”,⁷⁰ “ургамалын иш гол эгц шулуун”)⁷¹ гэсэн үгийн **yo-* гэдэг язгуур чухамдаа “гуранхай, дэлдийх” гэсэн утгатай байх ёстой бөгөөд *yodai* гэдэг нь (“богино юм дэлдийх”)⁷² (< **yo-dai*; жишээлбэл *salba- salbadai* (бас *salbada-*), *julbu- julbudai*, *siyu-* “to pull up” *siyudai* “bag”⁷³ шиг бололтой) **yo-* гэсэн үйл үгийн язгууртай байх ёстой гэмээр. Гэвч үүнийг таамаглахад ташаарч, *yoduyur*, *yojuyur* хоёроос үзвэл энэ тохиолдолд **yo* бол нэр үг байсан учир **Гау**-ын дотор хэлсний ёсоор *хураавар* гэсэн мэт үгтэй харьцуулж болохгүй.

Чингэхлээр *qobur* гэсэн үгийн утга нь “юмгүй болохын үр дүнг илэрхийлэх юм” → “цөөхөн, хомс” гэж хөгжиж ирснийг харж болно.

Гбδ) “Qoqu-” гэсэн үг

Үйл үг бүтээх *-rU* дагаварын үүргийг судлахаар цөөхөн жишээ байна. Нэр үгэнд залгах *-rU* дагаврыг (жишээлбэл *coqu-ru-* < *coqu*) үл тооцвол *görü-* (< **gö-rü-*), *gö-r*⁷⁴ (*görde-*, *görle-*) гэсэн үгс, *kirü-* (< **ki-rü-*), *kir(i)dke-*, *kire-*,⁷⁵ *kires-*, *kireg* гэсэн үгс, *körü-* (< *kö-rü-*), *kölde-*, *kölmü-*⁷⁶ гэсэн үгтэй холбоотой бололтой учраас *-rU* гэсэн дагаврын үүргийг яг нарийн тогтоох нь хэцүү тул өмнө **qo-* гэсэн язгуурын тухай өгүүлснээс болон *körü-*, *köldü-* гэсэн гэх мэт үгсийн утгаас үндэслэн үгийн утгыг нэг их өөрчлөхгүй гэж үзвэл *qoru-* нь **qo-* гэсэн үгтэй адилхан “юмгүй болох” гэсэн утгатай гэж тойруулан хэлж болно.

Гбε) “Qorçai-” гэсэн үг

Энэ үйл үг хэрвээ тухайлж буй үгсийн бүлэгт багтвал хийсвэр нэр үг бүтээх *-r* дагавраар⁷⁷ бүтсэн **qor* гэсэн нэр үгээс *-çAi* (< **-çAG-i*; *баацайх*, *баацгар* гэх мэтийг харьцуулна уу) гэсэн дагаврыг хэрэглэж үүссэн үйл үг байх ёстой боловч бүх *-çAi* дагавраар төгссөн үйл үгийг үгийн гарлын талаас үзвэл их асуудалтай⁷⁸ учир *-çA* гэсэн бүтээцтэй дагаврын дэлгэрэлт байсан болов уу. Үйл ба нэр үгэнд залгах *-çA* дагавар нь *-dA* дагаврын үүрэгтэй адилхан харагдана. Үүнд, *qoryuça-* нь *qoryuda-* гэсэнтэй утга адилхан (*qoryu* гэсэн үгээс үүссэн), *untuyuça-* гэсэн үйл үг *untuya(n)* гэсэн нэр үгээс, *jaruça-* гэсэн үйл үг *jaru-* гэсэн үйл үгээс, *tulyamça-*, *tulyamda-* хоёр *tulyam* гэсэн нэр үгээс тус тус үүссэн гэх мэт жишээг дурдаж болно. Дагавар *-çA*-ийн араас залгасан *-i* гэсэн дагавар нь үйл үгээс үүсмэл үйл үг бүтээх бөгөөд энэ

⁶⁸ Lessing нар 1960, 479 т.

⁶⁹ Дамбажав 2011, 2-р боть 714 т.

⁷⁰ Lessing нар 1960, 357 т.

⁷¹ Дамбажав 2011, 1-р боть 419 т.

⁷² Lessing нар 1960, 356 т.

⁷³ Lessing нар 1960, 700 т.

⁷⁴ Үйл үгэнд залгах *-r* гэсэн дагавар хийсвэр нэр үгсийг бүтээнэ (Porpe 1954, 49 т).

⁷⁵ Энэ *-rA* гэсэн дагавар үйл үг, нэр үгээс үүсмэл үйл үгсийг бүтээнэ (ж.: н.ү.-ээс *çögeke-re-*, *delbe-re-*, *büleke-re-* гэх мэт бөгөөд ү.ү.-ээс *neyidke-re-*, *seki-re-*, *buça-ra-* гэх мэт).

⁷⁶ *kölcü-* гэсэн үг утга зүйн үүднээс холбож болохгүй.

⁷⁷ Porpe 1954, 49 т.

⁷⁸ Би Чоймаа нарын бичсэн тонгоруу толь бичгийг (Чоймаа нар 2006) үндэслэн үзсэн.

үйл үгс нь *-Gar* гэсэн тэмдэг нэрийг бүтээх дагавартай холбогддог. Тэгэхлээр, **qo-r* “юмгүй болж байгаа байдал”, **qor-ца-* “юмгүй болж байгаа байдал бий болох” гэж үзэж болно.

Гбэ) “Qotui-, qongqur” гэсэн үг

Энэ хоёр утга зүйн үүднээсээ хэлэлцэж буй үгсийн бүлэгт багтах бололтой. Гэвч нарийн үзвэл, энэ хоёрын бүтэц нэлээд асуудалтай. *-tUi* гэсэн дагавар гэвэл зөвхөн нэр үгэнд залгадаг *-tU* гэсэн дагаварын дэлгэрэлт бололтой учраас *qotui-* гэсэн үгийн язгуур нь үйл үг байж болохгүй. Бас *-ng, -Q/GUr* хоёр хэсгээс бүрдсэн *-ngQUr* гэсэн дагаварын бүх жишээ нь асуудалтай, шинжлэхэд хэцүү. Тийм учраас эднийг хасах хэрэгтэй байна.

Гбн) “Qoçur-, qoki, qomsa”

qoki, qomsa энэ хоёр үг утга зүйн үүднээс тухайлж буй үгийн бүлэгт нийцэвч залгасан дагаварын хувьд асуудалтай байна. *qoki* гэсэн үг бол *-ki* дагавар нь нэр үгэнд залгадаг учраас **qo* нь үйл үгийн язгуур байж болохгүй учраас дээр сэргээсэн **qo-* гэсэн үйл үгтэй холбоогүй юм. Бас *-sa* гэсэн дагаварын үүрэг, гарал тодорхой бус улмаар ялангуяа хятадаас орсон үгэнд тааралддаг.

qoçur- гэсэн үг нь үйл үгэнд залгасан *-r* дагавраар нэмсэн шиг харагдаж байх (*sibqar-, sibqa-; qabsur-, qabsu-; qakir-, qaki-; jakir-, jaki-; tongyur-, tongyu-* гэх мэт) бөгөөд утга зүйн үүднээсээ⁷⁹ **qo* нь (*qoyin-a, qojim* зэрэг) “умар, ар” гэсэн утгатай үгэнд холбоотой бололтой.⁸⁰

Нэгтгэн үзвэл, *qoγ* гэсэн үгийн үндсэн утга бол **qo-* гэсэн язгуур нь “юмгүй болох” гэсэн утгатай бөгөөд **qo-γ* нь *-γ* гэсэн дагаврын үүргийн ёсоор⁸¹ “юмгүй болж байгаа юм, цөөхөн юм” гэсэн үндсэн утгатай байсан гэх нь зүйтэй. Түүнээс үүссэн утгыг амархан тайлбарлаж болно: “юмгүй болж байгаа юм, цөөхөн/багахан юм” → “үлдэгдэл” → “хаягдал” → “новш”.

Түүнчлэн монгол хэлний “хог” гэдэг үг хоёр үүсэл гаралтай бололтой. Эхийнх нь түрэг хэлнүүдийн нэгээс авсан үг, хоёрдугаарх нь уугуул монгол үг.

Хэрвээ МНТ-ны §234 зүйлийн хэллэгийн нэгдүгээр мөрийг дээр сэргээн гаргасан “хог” гэсэн үгийн утгаар шинээр уншвал:

qoq idejü

“цөөхөн / багахан идэж” гэсэн утгатай болно.

Хоёрдугаар мөрийн талаар, хомоол бол аргалаас хурдан бөгөөд дулаан багатай, илч муутай түлш болохыг малчид сайн мэдсээр ирсэн нь чухал ач холбогдолтой. Ганцхан хомоол түлбэл хоол хийхэд чухам тэнцэхгүй гал гарч байна. Иймээс, энэ мөр

qoma'ul tülejü

“хоол хийж болохооргүй юм түлж” / “багахан гал гаргаж” гэж ухаж болно.

Гэвч энэ тайлбар тов тодорхой бус. Хомоол түлж гэдгийг орчин тойрныг ариутгах арга хэмжээ гэж ухаарч ч болно. Харин энэ заншил дээр үеийн баримтгүй, дөнгөж саяхан баталсан байдалтай бөгөөд орчин цагийн заншлыг зүгээр дээр үед

⁷⁹ МНТ-д “zurückbleiben, sich verspäten” (хоцрох, хождох/хожимдох) утгатай (Haenisch 1939, 64 т).

⁸⁰ Starostin нар *qoçur-* гэсэн үгийг бусад зүйлсийн дунд орхон түрэг *qaç-* (“to run away, flee (убегать)”)–тай холбуулсан нь утга зүйн үүднээс үнэхээр холбогдолгүй (Starostin нар 2003, 751 т).

⁸¹ “[I]t form[s] nouns designating results of actions, abstract ideas” (Poppe 1954: 45 т).

шилжүүлж болохгүй учраас энэ тайлбар бас тов тодорхой бус байдаг. Харин энэ асуудлыг АНТ (асрагч нэргийн түүх) шийдэх байх (доошоо үзнэ үү).

Д) Өөр сурвалжууд

ЛАТ (Лувсанданзаны алтан товч)-д МНТ-ны *idejü* гэсэн үйл үг биш *abču* гэж уламжлагдаж ирсэн байна. АНТ-нд *qamijü* гэж тааралдсны хамтаар үнэхээр Ш.Чоймаагийн санаа зарим талаар зөв, анхны гар бичмэлийн *etejü* үйл үгийг МНТ-ны хятад ханзаар бичсэн гар бичмэлд *idejü* болгон буруу уншиж байсан нь бололтой. Гэвч нөгөө талаар XVII зууны энэ хоёр эх сурвалжуудад МНТ-нд уламжлуулсан, амархан ухагдахгүй *хог идэж* гэсэн хэллэгийг ойлгоогүй учраас өөрийн ойлголтоор тайлбарлаж хөрвүүлсэн байх боломжтой. Энэ асуудлыг тодорхой шийдэж чадахгүй боловч хамгийн магад боломжийг тэмдэглэж чадна.

Анхны гар бичмэлүүдэд хэрвээ үнэхээр *etejü* бичсэн бол үүнийг өөрчлөгдсөн юм уу өөрчлүүлсэн хэвээр яагаад уламжлуулсан, АНТ, ЛАТ-д янз бүрийн маягаар өөрчилж бичих ямар хэрэг байсан юм бэ гэж амархан тайлбарлаж чадахгүй.

Ингэхэд *Ockham's razor*-ын ёсоор АНТ, ЛАТ-д нь ойлгоогүй хэллэгийг өөрчлөөд бичсэн нь (ганцхан хэрэгтэй таамаглал) МНТ-д буруу бичсэн бөгөөд АНТ, ЛАТ-д аль нэгэн учраас (аль нэгэн гар бичмэлд уламжлуулсангүй) эхэн үгийг өөрчилснөөс нь (хоёр хэрэгтэй таамаглал) дээр.⁸²

АНТ, ЛАТ-д гарсан *ide*- юм уу *ete*- үгийн өөрчлөлтийн талаар утга зүйн үүднээс шийдвэрлэхээр үзэх ёстой.

МНТ, АНТ, ЛАТ, Хаадын үндэсний эрдэнийн товч-д *ete*- гэсэн үйл үг байхгүй бөгөөд дээр үеийн ховор үг байсан бололтой. Он Индү-ийн бичиг (1362)-д олдож буй *ulus-a qour-tu üyi:les-i eten tus-a-tu-yi yabuyu:lusaba:r*⁸³ (16-р мөр) гэдгийг “улсад хортой үйлсийг этэн (≈ суга татан) тустайг явуулсаар” гэж ойлгоно. F. W. Cleaves “*eten*”-ыг “*extirpating*” гэж орчуулсан бөгөөд монгол *eten* гэдэг нь хятад зэрэгцээ хувилбарт тааралддаг “*removed*” гэсэн утгатай үйлийг хөрвүүлснийг тэмдэглэж бичсэн.⁸⁴

Бусад толь бичигт *ete*- үйл үгийн өгсөн утга нь “*to pick, pluck out*”,⁸⁵ “*kratzen od. in der erde graben (nicht tief), schaufeln, pflügen tsas e. schnee schaufeln, wegfeigen (mit dem fuße, z.b. das pferd)*”,⁸⁶ “*выгребать; отметать*”,⁸⁷ “*urtu yaγum-a-yin ijügür-i nögege yaγum-a-yin douyuur širγyulju tegün-iyer nögege yaγum-a-yi tülkikü [...] abču qayaqu [:] yaqai čAr-A-dU ÜrdÜgdekü*”,⁸⁸ “*этүүр хэрэглэн өлгөх хамах; этэх хамах х о р ш .; хоол этэх*”⁸⁹ бий. Дундад үеийн монгол хэлний бусад сурвалж (Поппе 1938, Haenisch 1939, Жанчив 2002, Golden 2000), Ойрад (Kueger 1978), Ордос (Mostaert 1941-44), Монгол (Smedt/Mostaert 1933)-д энэ үйл үг байхгүй. Эртний

⁸² Бас ялангуяа *lectio difficilior*(хэцүү уншлага)-ыг *lectio potior*(хүчтэй уншлага) гэж үздэг байна. Учир нь амархан ойлгогдохгүй юмыг ойлгомжтой болгон өөрчлөх нь ойлгомжтой юмыг ойлгогдохгүй юм болгон өөрчлөх нь илүү магад гэсэн үг. Гэвч энэ бол гарцаагүй бус.

⁸³ Tumurtogoo 2006, 29 т.

⁸⁴ Cleaves 1949, 108 т.

⁸⁵ Lessing 1960, 335 т.

⁸⁶ Ramstedt 1935, 128 т. Zwick (1853)-д энэ үйл үг байхгүй.

⁸⁷ Муниева 1977, 705 т.

⁸⁸ C.Noᠮᠵᠢᠨ 1999, 260-1 т.

⁸⁹ Я.Цэвэл 1966, 891 т. И.Дамбажав (2010)-д төстэй.

түрэгийн *et-* “to organize, put in order”,⁹⁰ “совершать/устроить”⁹¹ гэсэн үйл үг бас *ete-* хэвээр Монголд орсон бололтой (Kowalewski: “положить, накладывать (пищу, корм) в посуду”,⁹² Голстунский: “Класть, накладывать, наливать во посуду (пищу, корм)”, I. J. Schmidt: “Speise oder Futter in ein Gefäß thun”⁹³ гэсэн).

Тэгээд *ete-* гэсэн үйл үгийн гурван утгыг тэмдэглэж болно (дандаа ойролцоо): 1-рт “өлгөж (ухаж) авах”, 2-рт “маажиж ухах” (зөвхөн хальмагт), 3-р “савд тавих, асгах”.⁹⁴ 3-р утга нь нэг ба 2-р утгатай холбоогүй, ижил бүтээвэртэй хэдий ч ялгаатай үйл үгийнх буй бөгөөд түрэг хэлүүдийн нэгээс олсон бололтой (*жиш.* эртний түрэг *et-*). 2-р утга зөвхөн хальмагт олдож бий бөгөөд Он Индү-ийн бичгийн дээр үеийн утга бас 1-р утгатай төстөй шиг харагдаж байх учраас *ete-* гэдгийг уг нь “өлгөж (ухан) авах” гэж тэмдэглэж болно. Түүнчлэн уг нь “хураах, цуглуулах” гэсэн утга байхгүй байсныг Он Индү-ийн бичгээс түвэггүй үзэж болно. Цаашдаа орчин үеийн “хуруугаар этэх” гэдэг нь ойролцоогоор “хуруугаар хальт цохиж шүргэн авах” утгатай. Нэг ба 2-р утгыг нэгтгэх гэвэл “(үзүүртэй) юмаар дороос нөгөө юмыг өлгөн авах” (эндээс бас Ramstedt-ын *schnee schaufeln* < “цасан доруур бариж авах” !?) гэж тойруулан ярьж болно. Харин *qoγ* гэсэн үгийг “тоос” (түрэг үг), “хэмхэлсэн ногоо” (хятад тайлбар), “бага юм” (бидний дээр олсон угийн утга) хамаагүй гэж үзвэл энэ тохиолдол бүрэнд *ete-* үйл үгийн утга сайн нийцэхгүй.

Харин дээр үед ч “хог” гэдэг нь орчин үеийн утгатай байсан гэж баталж чадахгүй боловч үгүйсгэж ч чадахгүй. Ийм тохиолдолд “хог” бас идсэн малын яс мас байсан бололтой. Гэхдээ ингэхээр дахиад нэг таамагласан юм байдаг (бас энэ тохиолдолд *ete-* үл нийцэн “хог савардах” юм уу “хамах, авах” шууд гэдэг нь дээр байх сан).

Тэгээд энэ хэллэгийн нэгдүгээр мөр уг нь “хог идэж” гэсэн талаар утга зүй сайн нийцэх төдийгүй ганцхан (бусад эх сурвалжийн талаарх) таамаглал л хэрэгтэй учраас энэ уншил хамгийн магад байна. Харьцуулбал “хог этэж” гэвэл утга зүй нийцэхгүй бөгөөд хоёр таамаглал хэрэгтэй (дээр үзнэ үү).

Хоёрдугаар мөрийн “хомоол түлж” гэдэг нь “газар ариутгаж” эсвэл “бага гал түлж” гэсэн аль утгатай вэ гэвэл “газар ариутгаж” гэсэн тохиолдолд нэг илүү таамаглал хэрэгтэй (дээр үзнэ үү) боловч шууд шийдэж чадахгүй. Гэвч АНТ-д энэ хэллэг хоёр мөртэй л биш гурван мөртэй байна.⁹⁵

18a05-07

[...] *qorıqan-dur*

baqıju qoq qatıju qotuqul tüle-

jü yabutuqai [::]

горхид бууж

хог хамаж

хомоол түлж явтугай

⁹⁰ Clauson 1972, 36 т.

⁹¹ Надеяев нар 1969, 186 т.

⁹² Kowalewski 1844-49, 200 т.

⁹³ Голстунский 1895, 83 т.

⁹⁴ Schmidt 1835, 33 т.

⁹⁵ Дагуур хэлэнд “этэ-” бол “побеждать” гэсэн утгатай (Тодаева 1986, 141 т).

Дундад үеийн монгол хэлэнд эхний авианы хоолойн угаар хэлэгдэх гийгүүлэгч бүр дуугүй бөгөөд “горхи”-ийг *qorqan, qorqon, qoroqan* гэж бичсэн улмаар сайхан толгой холбож байх учраас “*qoruqan-dur baquju*” үнэхээр дээр үеийн вариант байж болно.

Хам сэдвийн үүднээс горхи нь багахан устай гол байдаг учраас “горхид бууж” бол “бага ус ууж” гэсэн утгатай гэж бодол төрж байна. Түүнчлэн энэ мөр бол манай хэллэгийн зөв ойлголтын нэг нэмэлт заалт байж болно:

багахан ус ууж

багахан юм идэж

багахан гал түлж явтугай гэж утга агуулгын зохицолтой. Өөр вариант бол “(аль нэгэн шалтгаанаас) горхид бууж хог идэж газар ариутгаж явтугай” гэж утга агуулгаар сайн таарахгүй.

Тийм учраас “хомоол түлж” гэдэг нь “бага гал түлж” гэсэн утгатай байсан нь утга агуулга зохицохоор үл барам аль ч таамаглал хэрэггүй учраас утга агуулга зохицохгүй, таамаглалтай “газар ариутгаж” гэснээс зохилтой мэт.

Е) Дүгнэлт

Өгүүлсэн бүхнийг дүгнэн хэлбэл, “Дөдэй чэрби даран аж ордын хойноос хог идэж хомоол түлж явтугай” гэсэн хэллэг нь “Дөдэй чэрби (ордыг) хамгаалж (чухал ажил хийх, том алба хааж буй газар болох) ордын хойноос [багахан ууж] багахан идэж багахан галлаж явтугай” шууд утгаар тэмдэглэх зүйтэй. Харин шилжсэн утга нь “Дөдэй чэрби хамгийн чухал ажил хийх хүн болохоор **амарч тайван суулгүй амсхийх төдий байж, дандаа сэрэмжтэй байх ёстой**” хэмээн тайлж болно.

НОМ ЗҮЙ

Монгол Хэлний

И. Дамбажав: Оюун Билгийн Мэлмийг Нээгч Аялгуу сайхан Монгол Үгийн Дээж. УБ: Өнгөт Хэвлэх ХХК, 2010.

Ё.Жанчив: Дөрвөлжин үсгийн монгол дурсгал. Улаанбаатар: Centre for Mongol Studies, 2002 (Monumenta Mongolica: Tomus III).

Д.Заяабаатар: Асрагч нэртийн түүх. УБ: МУИС, 2011.

С.Norjin: Mongyol kelen-ü toli. Köke qota: Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, 1999.

Д. Отгонтуяа: “Монгол Нууц Товчоон”-ы нэгэн хэлцийн орчуулгын тухайд. Монгол Судлал XXVII (285), 2007. 171-176 т.

Г. Сүлд-Эрдэнэ нар: Монгол Хэлний Өвөрмөц Хэлний Толь. УБ: Монсудар, 2013.

Я.Цэвэл: Монгол хэлний товч тайлбар толь. УБ: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, 1966.

Ш. Чоймаа нар: Монгол Бичгийн Хэлний Тонгоруу Толь. II боть. Хөх хот: МУИС-ын хэвлэлийн газар, 2006.

Ш. Чоймаа: Монголын Нууц Товчоо – Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг. УБ: «Мөнхийн Үсэг» ХХК, 2011.

Ш. Чоймаа нар: Монгол хэлний хадмал толь. УБ: Соёмбо принтинг, 2011.

Гадаад Хэлний

G. Clauson: An Etymological Dictionary of Pre-Thirteenth-Century Turkish. Oxford: Clarendon Press, 1972.

F. W. Cleaves: The Sino-Mongolian inscription of 1362 in memory of Prince Hindu. Harvard Journal of Asiatic Studies, 12 (1949), 1-133 т.

M. Erdal: Old Turkic Word Formation – A Functional Approach to the Lexicon. Vol. I. Wiesbaden: Harrassowitz, 1991.

A. von Gabain: Alttürkische Grammatik mit Bibliographie² Lesestücken und Wörterverzeichnis, auch Neutürkisch. Leipzig: Harrassowitz, 1950 .

P. B. Golden: The King's Dictionary. The Rasûlid Hexaglot: Fourteenth Century Vocabularies in Arabic, Persian, Turkic, Greek, Armenian and Mongol. Leiden: Brill, 2000.

К. Ө. Голстунский: Монгольско-Русский Словарь. Томъ первый. Санкт Петербургъ, 1895.

К. Ө. Голстунский: Монгольско-Русский Словарь. Томъ второй. Санкт Петербургъ, 1894.

E. Haenisch: Wörterbuch zu Manghol Un Niuca Tobca'an (Yüan-Ch'ao Pi-Shi) – Geheime Geschichte der Mongolen. Leipzig: Harrassowitz, 1939.

E. Haenisch: Die Geheime Geschichte der Mongolen – Aus einer mongolischen Niederschrift des Jahres 1240 von der Insel Kode'e im Keluren-Fluß. Leipzig: Harrassowitz, 1948 .

J. É. Kowalewski: Dictionnaire Mongol-Russe-Français. Kazan: Imprimerie de l'Université, 1844-49.

J. R. Krueger: Materials for an Oirat-Mongolian to English Citation Dictionary. Bloomington: Mongolia Society, 1978.

F. Lessing nar: Mongolian-English Dictionary. Berkeley/Los Angeles: University of California Press, 1960.

L. Ligeti: Histoire Secrète des Mongols. Budapest: Akadémiai Kiadó, 1971.

A. Mostaert: Dictionnaire Ordos. Peking: The Catholic University, 1941-44.

Б. Д. Муниева: Калмыцко-Русский Словарь. Москва: Издательство «Русский Язык», 1977.

В. М. Наделяев нар: Древнетюркский Словарь. Ленинград: Издательство «Наука», 1969.

U. Onon: The Secret History of the Mongols – The Life and Times of Chinggis Khan. London: Routledge, 2001 .

Н. Понне: Монгольсий Словарь Мукаддимат ал-Адаб. Москва: Издательство Академии Наук СССР, 1938.

N. Poppe: Grammar of Written Mongolian. Wiesbaden: Harrassowitz, 1954.

N. Poppe: Vergleichende Grammatik der Altaischen Sprachen – Teil 1 Vergleichende Lautlehre. Wiesbaden: Harrassowitz, 1960.

I. de Rachewiltz: The Secret History of the Mongols – A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century. 2 Volumes. Leiden/Boston: Brill, 2004.

G. J. Ramstedt: Kalmückisches Wörterbuch. Helsinki: Suomalais-Ugrilainen Seura, 1935.

- I. J. Schmidt*: Mongolisch-Deutsch-Russisches Wörterbuch. St. Petersburg: Kaiserliche Akademie der Wissenschaften, 1835.
- S. A. Starostin нар*: Etymological Dictionary of the Altaic Languages. Leiden: Brill Academic Publishers, 2003.
- J. Ch. Thomas*: Zur Etymologie von Mongolisch noqai “Hund” – Überlegungen zur Sippe um vorgemeinmongolisch *√no-. Zentralasiatische Studien (ZAS) (40), 2011. 313-341 т.
- Б. Х. Тодаева*: Дагурский язык. Москва: Издат. Наука, 1986.
- D. Tumurtogoo*: Mongolian Manuscripts in Uighur-Mongolian Script (XIII-XVI Centuries). Taipei: Institute of Linguistics, 2006.
- H.-P. Vietze*: Wörterbuch Mongolisch-Deutsch. Berlin: DAO-Verlag, 2006 .
- W. Zwick*: Handbuch der Westmongolischen Sprache. Hufingen: Heinemann, 1853.